



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/481

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын тогтоолын дагуу хэрэгжсэн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүчилтөрөгчийн үйлдвэрээс Хүүхдийн эмнэлэг рүү хүчилтөрөгийн хийгээр хангах системийг өргөтгөж, угсарч, суурилуулах ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд: Л.Батгэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Г.Нарантуяа - Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн  
тоног төхөөрөмжийн инженер

Б.Баярсүрэн - Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн  
ерөнхий нягтлан бодогч

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн


Б.Цолмон - "Петрохими" ХХК-ийн инженер

Нарийн бичгийн

дарга: С.Дорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн хүчилтөрөгчийн үйлдвэрээс Хүүхдийн эмнэлэг рүү хүчилтөрөгийн хийгээр хангах системийг өргөтгөж, угсарч, суурилуулах ажлыг гүйцэтгэгч "Петрохими" ХХК-ийн ажлыг ажлын даалгавар, техникийн тодорхойлолтын дагуу шалгаж, хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

Zah A/481 Kh